



## НИЙСЛЭЛИЙН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 03 сарын 09 өдөр

Дугаар А/А4

Улаанбаатар хот

Г Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан ажлын хариуцлагыг сайжруулах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 45 дугаар тогтоол, Улсын Онцгой комиссын 34 дүгээр өргөтгөсөн шуурхай хурлын тэмдэглэл, Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/108 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гамшгийн өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангаж, цаг үеийн нөхцөл байдал, ажлын ачаалалтай уялдуулан ажилтан, албан хаагчдын ажлын цагт зохицуулалт хийж, хуваарь гарган ажлын тусгай горимд шилжүүлэн ажиллуулсантай холбогдуулан ажлын цаг ашиглалтад хяналт тавьж ажиллахыг хэлтэс, албадын дарга нар, байр хариуцсан менежерүүдэд үүрэг болгосугай.

2. НЗЗ-ны байрууд, Баянхошуу, Сэлбэ дэд төвүүдийн байрны жижүүр, Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвүүдэд ажиллаж байгаа цагдаагийн болон харуул хамгаалалтын ажилтнуудын хариуцлагыг өндөржүүлж ажиллахыг Үйлчилгээний албаны дарга /М.Алтантуяа/, Байр хариуцсан менежерүүдэд тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлагаар ханган ажиллахыг Орлогч дарга (Ч.Однасан, Б.Галмандах), Захиргаа, санхүүгийн хэлтэс (Ч.Шинэчимэг) нарт тус тус даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



ХЭРДЭНЭБИЛЭГ

1150500047